

## Суралцагчдын “бие хүний үнэт зүйл” ба мэргэжилтний хандлагын уялдаа холбоо

Сүхээ Амартүвшин

*Монгол улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургууль, Сэтгүүл зүйн тэнхим*

Холбоо барих зохиогч: [amartuvshin@msue.edu.mn](mailto:amartuvshin@msue.edu.mn)

ORCID: <https://orcid.org/0000-0001-8940-3268>

---

Хүлээн авсан: 2023.02.22

Засварласан: 2023.05.12

Хэвлэлтэд авсан: 2023.05.22

---

### Хураангуй

Сэтгүүлч мэргэжлээр суралцагчдын бие хүний үнэт зүйлсийг сургалтын чанартай холбож судалсан судалгаа цөөнгүй байдаг. Харин “бие хүний үнэт зүйлс” нь тэдэнд сургалтаар төлөвшүүлж буй сэтгүүлч мэргэжлийн хандлагатай хэрхэн холбогдох талд анхаарал хандуулсан судалгаа хомс байна. Иймээс бид бие хүний үнэт зүйлс болон мэргэжлийн хандлагын хоорондох уялдаа холбоог МУБИС (Монгол Улсын Боловсролын Их Сургууль)-ийн сэтгүүлчийн ангийн нийт оюутны 45 оюутнаас (нийт оюутны 53.09%) хувь хүний үнэт зүйлийг нь тодорхойлох асуулга судалгаа авч хийлээ. Өмнөх судлаачдын боловсруулсан “Нэгэн хүний амин хүрээний үнэт зүйлийн гурвалууд” загвараар оюутнуудаас ахуйн, амины, ухамсрын түвшний тус бүр гурван үнэт зүйл сонгох нөхцөлөөр асуулга авч, SPSS - 26 программд боловсруулалт хийв. Гарсан үр дүнг мэргэжлийн сургалтын агуулга, суралцагчдад төлөвшүүлэх хандлагатай холбон шинжилсэн нь энэхүү өгүүллийн шинэлэг болон хязгаарлагдмал талыг илтгэнэ. Гурвалуудаас ахуйн түвшний үнэт зүйлийн сонголт ихээхэн тархмал шинжтэй, харин амины түвшний үнэт зүйлийн хувьд “Эрүүл мэнд” сонголт илүү давтамжтай (n = 44) илэрсэн бол үүний дараагаар “Эрх чөлөө” (n = 27) болон “Оюун ухаан, мэдлэг боловсрол” (n = 25) гэсэн сонголтууд гарсан байна. Ухамсрын түвшний үнэт зүйлийн сонголт нь харьцангуй тархмал шинжтэй үр дүн гарлаа. Энэхүү үр дүнг сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөр дэх “Сэтгүүлч мэргэжилтний хандлага”-тай тодорхой байдлаар холбогдоно гэх таамаглал дэвшүүлэн, зарим шинжилгээг хийсэн болно. Үүнд үндэслэн энэхүү өгүүллээрээ мэргэжлийн сургалтад мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхээс бие хүний үнэт зүйлд суурилж суралцагчдад мэргэжлийн хандлагыг төлөвшүүлэх нь илүү чухал гэсэн үзэл санааг дэвшүүллээ.

**Түлхүүр үг:** Үнэт зүйл, мэргэжлийн онцлог, сэтгүүл зүйн үндсэн зарчим, мэргэжилтний хандлага



## Удиртгал

Хувь хүний үнэт зүйлээ дагах уу? нийгмийн үнэт зүйлийг эрхэмлэх үү? гэдгээс сэтгүүлчийн нийгмийн байр суурь, нийгэм олон нийтийн өмнө хүлээх үүрэг хариуцлагын асуудал яригддаг. Олон нийтийн мэдэх эрхэд үйлчлэх зарчим баримталдаг сэтгүүлчийн хувьд асуудалд төвч байр сууринаас хандах, туйлшрахгүй ажиллах ёстой болдог. Энэ нь мэдлэг, ур чадвараас гадна хамгийн чухал нь мэргэжлийн хандлага хэрхэн төлөвшсөнөөс ихээхэн шалтгаалдаг.

Орчин цагт мэргэжил эзэмшүүлэх сургалтад бие хүний үнэт зүйлийг мэргэжлийн мэдлэг, чадвар олгох, хандлага төлөвшүүлэхэд харгалзан үзэх нь чухал гэсэн үзэл баримтлал давамгайлах болжээ. Сэтгүүл зүйн сургалтад ч үүнийг хөндөх боллоо. Гол нь тэдгээр үнэт зүйлсийг хэрхэн мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлагатай холбож тайлбарлах вэ? гэдэг асуулт урган гарч байна. Үүнийг тодруулах зорилгоор бид суралцагчдынхаа хувь хүний үнэт зүйлийг судалж, тэдний нийтлэг үнэт зүйлд сэтгүүл зүйн сургалтын агуулга хэрхэн нөлөөлж, мэргэжлийн хандлага төлөвшихөд ямар холбоо хамаарал байж болохыг шинжлэн тайлбарлахыг оролдлоо.

Бие хүний амьдралын туршид болон оршихуйд үзэл бодол, хандлага, ерөнхий зан төлөв, шийдвэр гаргалт, харилцахуйд хамгийн чухал нөлөө үзүүлдэг зүйл нь түүний эрхэмлэгч үнэт зүйл юм (Санчес, 2000, х.24). Товчхондоо хүний зан үйлийг чиглүүлэгч итгэл үнэмшлийг үнэт зүйл гэнэ. Тэгээд ч бие хүний үнэт зүйл нь тодорхой нөхцөл байдлаас давсан, хүссэн зорилго эсвэл зан үйлийн хэлбэрт хамаарах итгэл үнэмшил гэж ойлгогддог (Schwartz, 2010, р. 21).

Үнэт зүйлийг мэдлэг, чадвартай холбож судалсан судалгаа цөөнгүй байна. Үнэт зүйлийн судалгаанууд дотор үнэт зүйл чадамжийн цөм болохыг нотолсон Жон Эрпенбек (Erpenbeck, 2018, р.6), А.Фишер (Fischer, 2019, р.31) нарын судалгаа хамгийн сонирхолтой нь юм. Тэгвэл хандлага болон үнэт зүйл хоорондын уялдаа холбоог судалсан Паул, Ханел, Колин Фоад нар “үнэт зүйлс, хандлагын хоорондын уялдаа холбоо нь бат бөх, уян хатан байдаг” (Paul et al, 2021, р.3) гэж дүгнэжээ.

Сэтгүүл зүйн сургалтад үнэт зүйлийн судалгаа цөөн боловч хийгджээ. Гол төлөв суралцагчдын сургалтын чанарт бие хүний үнэт зүйл хэрхэн нөлөөлж буйг судалсан байна. Түүнчлэн сэтгүүл зүйн мэргэжлийн үнэт зүйлийн судалгаа ч цөөн хийгдсэн байна. Ийм судалгаанаас Нико Дрок шилжилтийн үеийн мэргэжлийн ирээдүйг Европын сэтгүүл зүйн багш нар хэрхэн харж буйг судалсан бүтээлдээ (Drok, 2019, р.17) сэтгүүл зүй дөрвөн үндсэн үнэт зүйлтэй гэж үзжээ. Эдгээр нь хэрэглэгчид, цаг хугацаа, бодит байдал, хүч нөлөө юм. Гэхдээ мэргэжлийн үнэт зүйлийн судалгаа бидний сэдэвтэй хамаарахгүй.

Суралцагчдын “бие хүний үнэт зүйлс” мэргэжлийн сургалтаар онолын мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэх явцад мэргэжлийн чиг баримжаагаар өргөжин тэлж, өөрчлөгдөх, баталгаажих боломжтой. Хамгийн гол хүчин зүйл нь мэргэжлийн зарчим, хандлагыг ухамсарлах, мэргэжилтний хувьд төлөвших явдал мөн. Энэхүү таамаглалаа нотлохын тулд оюутнуудаас “нэгэн хүний амин хүрээний үнэт зүйлийн гурвалууд”-ын асуулга судалгаа авч, улмаар сэтгүүл зүйн

мэргэжлийн онцлог, үүрэг зорилго, зарчимтай холбож тайлбарлах, мөн сургалтын хөтөлбөр дэх суралцагчдад төлөвшүүлэх хандлагын уялдаа холбоонд шинжилгээ хийж үзлээ.

### Судалгааны арга зүй

Судалгаанд сэтгүүлчийн ангийн нийт 83 оюутны 45 оюутан хамрагдлаа. Судалгаанд сэтгүүлчийн ангийн суралцагчдын талаас илүү (нийт оюутны 54.2%) хувь нь оролцсон тул түүвэр олонлог маань эх олонлогоо хангалттай төлөөлж чадна гэж бид үзсэн. Түүврийн хувьд анги курсийн оюутны тоон харьцаа, төлөөллийг харгалзахын зэрэгцээ өөрсдийнх нь идэвхэд түшиглэсэн. Судалгаанд оролцогчдын харьцааг доор (Хүснэгт 1) харуулав. Асуулга судалгааг 2023 оны 2-р сарын 16-23-ны хооронд 7 хоногийн дотор авч, үр дүнг SPSS-26 программ хангамжийн 9-р хувилбарыг ашиглан боловсруулсан.

#### Хүснэгт 1

Сэтгүүлч мэргэжлээр суралцагчид болон судалгаанд оролцогчдын статистик

Курс	Анги дахь нийт оюутны тоо	Судалгаанд хамрагдсан тоо	Судалгаанд хамрагдсан нийт оюутны тоонд харгалзах хувь
1-р курс	28	18	64.29%
2-р курс	22	10	45.45%
3-р курс	19	10	52.63%
4-р курс	14	7	50%
Нийт	83	45	54.21%

Үр дүнг мэргэжлийн онолын бүтээлүүд дэх сэтгүүл зүйн үйл ажиллагааны онцлог, үүрэг зорилго, зарчмын талаарх үзэл онолуудтай холбон шинжилж, суралцагчдын бие хүний үнэт зүйлс хэрхэн сургалтын агуулгатай холбогдож болохыг тайлбарлах, мөн сургалтын хөтөлбөр дэх суралцагчдад эзэмшүүлэх мэргэжлийн хандлагын хамаарлыг “Сэтгүүлч мэргэжилтний хандлага”-уудтай ямар уялдаа холбоо байгааг шинжлэх замаар таамаглалаа нотлохыг зорьсон.

Бидний зорилго бол сэтгүүл зүйн хөтөлбөрөөр суралцагчдын хувь хүний үнэт зүйлийг “Нэгэн хүний амин хүрээний үнэт зүйлийн гурвалууд” (Сүхболд, 2021, х.104,105) загварыг ашиглан асуулгын аргаар судалгаа авч, улмаар асуулгын үр дүнг нэгтгэн “хүмүүний үнэт зүйлийн гурвал” загварт оруулан тооцоолж, суралцагчдынхаа үнэт зүйлийн ерөнхий зураглалыг тодорхойлоход оршино. Нэгэн хүний амины хүрээний оршихуйн, ухамсрын, ахуйн үнэт зүйлийн 27 бүрдүүлбэр загварыг асуулга болгон зохиомжилсныг шууд ашиглав.

#### Хүснэгт 2

Нэгэн хүний амин хүрээний үнэт зүйлийн гурвалууд

Д/д	Ахуйн түвшин	Амины түвшин	Ухамсрын түвшин
1	Байгаль дэлхийн хамгаалал	Эрүүл мэнд	Хүндлэл (нэр төр)

2	Эх орон, газар шороо	Ажил хөдөлмөр	Итгэл үнэмшил, сүсэг бишрэл
3	Хүмүүнлэг иргэний нийгэм	Амьдрах ухаан, эв дүй	Энэрэх, нигүүлсэх сэтгэл
4	Эдийн засаг (эд хөрөнгө, баялаг)	Эрдэм чанар (авьяас чадвар)	Ёс суртахуун
5	Эх түүх, нүүдэлчин соёл, мал аж ахуй	Гэр бүлийн аюулгүй байдал	Хүн ёс, хүн чанар
6	Тусгаар тогтнол	Оюун ухаан, мэдлэг боловсрол	Хамтач үзэл (хамтын ажиллагаа, багаар ажиллах)
7	Ёс заншил, өв соёл, уламжлал	Хөгжил (Тогтвортой хөгжил)	Эх хэл (хэрэглээ соёл)
8	Цаг хугацаа	Эв эе (найрамдал, энх тайван)	Нийгмийн байр суурь (нэр хүнд, алдар гавьяа)
9	Хүний эрх, тэгш байдал	Эрх чөлөө	Нөхөрсөг харилцаа

*Эх сурвалж: Сүхболд, 2021, х.104-105*

Асуулгад оролцогч ахуйн түвшинд - 3, амины түвшинд – 3, ухамсрын түвшинд – 3 буюу өөрийн нийт 9 үнэт зүйлийг сонгосон. Оролцогч бүрийн сонгосон 9 үнэт зүйлээр дундажлаж суралцагчдын нийтлэг үнэт зүйлийг тодорхойлсон юм. Энэхүү нийтлэг үнэт зүйл нь сэтгүүл зүйн боловсрол эзэмшихэд ямар хамааралтай, ялангуяа мэргэжлийн үнэт зүйл, зорилго, үүрэг хариуцлага, ёс зүйн талаарх мэдлэг, чадвар эзэмшиж, хандлага төлөвшихөд нөлөө үзүүлдэг гэх таамаглалаа нотлохыг зорьсон.

**Найдвартай байдал:** Судалгаанд ашигласан нэгэн хүмүүний амины хүрээний үнэт зүйлсийн гурвалын бүрэлдүүлбэр үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх нь Cronbach-ийн альфа хэмжигдэхүүний хувьд итгэлцүүр буюу найдвартай шинж нь  $\alpha=0.714$  буюу шууд хэрэглэх боломжтой өндөр үр дүнтэй (Сүхболд, 2021, х.110) байгааг шууд ашигласан.


### **Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг**

*Үнэт зүйлс, тэдгээрийг сэтгүүл зүйн мэргэжлийн онцлог, үүрэг зарчим, мэргэжлийн хандлагатай тайлбарлах нь*

**Ахуйн үнэт зүйл:** Суралцагч бүр ахуйн түвшний өгөгдсөн 9 үнэт зүйлээс өөрийн гурван сонголтоо хийсэн бөгөөд дараах үр дүнгүүд (Зураг 1) гарсан. Сонголтын давтамж, график илэрхийллийг ажиглавал ахуйн түвшний үнэт зүйл нь ихээхэн тархмал, үүгээрээ нийтлэг үнэт зүйл бага харагдаж байна.

Зураг 1

Нэгэн хүний амин хүрээний үнэт зүйлсийн хариултад илэрсэн давтамж



Тайлбар: Үнэт зүйлст харгалзах дугаарыг Хүснэгт-2-оос харна уу.

Ахуйн түвшний үнэт зүйлсээс суралцагчид “Хүний эрх, тэгш байдал” гэсэн үнэт зүйлийг хамгийн олон давтамжтай ( $n = 24$ ) сонгожээ. Үүний дараагаар “Тусгаар тогтнол” ( $n = 19$ ) болон “Хүмүүнлэг иргэний нийгэм” ( $n = 16$ ) гэсэн үнэт зүйлүүд (Зураг 1) илүү сонгогдсон байна.

Эдгээр үнэт зүйлийн сонголт нь сургалтын хөтөлбөрөөр эзэмшиж буй онол-практикийн мэдлэг дэх “Хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Энэ эрх нь бие даасан үзэл бодолтой байх, төрийн эрх мэдэлтнүүдийн нөлөө болон ямар нэгэн хил хязгааргүйгээр мэдээлэл, үзэл санааг хүлээн авах, солилцох эрхийг хамаарна” (Committee, 1948, p.74) гэсэн мэдээллийн эрх чөлөөний баталгааг танин ухамсарлаж, дээдлэн эрхэмлэх ёстой гэдэг мэргэжлийн хандлага суралцагчдад бүрэлдэж буйг илтгэж байна. Мөн ардчиллын үндсэн зарчмыг дээдлэх, сэтгүүл зүйн үйл ажиллагаа иргэний мэдэх эрхэд үйлчилж олон түмнийг бодит мэдээллээр хангах үндсэн зорилготой гэсэн үзэл баримтлалыг эрхэмлэх хандлага төлөвшиж буйг илтгэнэ.

Хоёрдугаарт, “Тусгаар тогтнол” хэмээх үнэт зүйлтэй байгаа нь монгол хүн бүр, ялангуяа түүнийг сахин хамгаалах чин эрмэлзлэл сэтгүүлч хүнд байх ёстой эрхэм чанарыг илтгэж байна. Энэ нь үндэсний аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлын талаарх үзэл баримтлалыг мэргэжлийн чиг баримжаа болгож байхад нөлөөлөх учиртай. Үүний дээр “Эх орон, газар шороо” гэх үнэт зүйлийг олон давтамжтай ( $n = 15$ ) сонгосон нь харилцан хамааралтай гэж үзэж болно. Ийм үнэт зүйлтэй байхад сэтгүүлч эх орон, газар шороотой холбоотой аливаа асуудлыг

хөндөн, олон түмний анхаарлыг төвлөрүүлэх, хяналтын үүргийг хэрэгжүүлэх хэвлэл мэдээллийн чухал үүргүүдээ ухамсарлан ажиллах үндэс болно.

Гуравдугаарт сонгогдсон “Хүмүүнлэг иргэний нийгэм” гэсэн чухал үнэт зүйлтэй байна гэдэг ардчилсан нийгмийнхээ мөн чанарыг таниад зогсохгүй нийгмийнхээ түүхээ болж, иргэний нийгмийг бүтээхэд чөлөөт хэвлэлийн үүрэг оролцоо чухал, иргэний сэтгүүл зүйн үндсэн чиг үүрэг гэдгийг танин ухамсарласны илэрхийлэл юм. Иргэний нийгэм бол ардчиллын үйл явцад маш чухал ач холбогдолтой бөгөөд ардчиллын тусгал юм (Наранжаргал, 2021, х.188). Сэтгүүл зүй бол нийгмийн толь гэсэн тайлбар бүхий мэргэжлийн талаарх нарийн ойлголт, итгэл үнэмшилд хөтөлөгдөж буйг харуулж байна. Түүнчлэн “хүнлэг энэрэнгүй байх зарчим”-аа эрхэмд үзэх үзэл төлөвшиж, хариуцлагатай сэтгүүл зүйн итгэл үнэмшлээр суралцаж буй юм.

Ахуйн түвшний дээрх хамгийн олон сонгогдсон үнэт зүйлсийн араас “Цаг хугацаа” (n = 15), “Байгаль дэлхий хамгаалалт” (n = 14), “Эдийн засаг (эд хөрөнгө, баялаг)” (n = 14), “Ёс заншил, өв соёл” (n = 14) зэрэг үнэт зүйлс олон давтамжтай сонгогдсон нь суралцагчдын үнэт зүйлийн тогтолцоо олон талтай, тархмал шинжтэйг илтгэж байна. Энэ бол суралцагчдын ахуйн түвшний үнэт зүйлийн нийтлэгийг илтгэх сонголтын харилцан адилгүй байдал гэдгийг анхаарч ажиглавал зүйтэй. “Байгаль дэлхийгээ хамгаалах”, “ёс заншил, өв соёлоо дээдлэх” нь монгол хүнд байх тогтсон үнэт зүйл билээ. “Эдийн засаг (эд хөрөнгө, баялаг)” бол санхүүгийн эрх чөлөө, аж төрөх хүсэл мөрөөдөлтэй холбоотойн зэрэгцээ чөлөөт хэвлэл бол эдийн засаг, санхүүгээс хараат бус эсэх (Батзориг, 2019, х.3) гэсэн хэвлэлийн хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийг ухамсарлаж, чөлөөт хэвлэлийн номлолд үнэнч байх итгэл үнэмшил төлөвшсөний ч илрэл болж болно. “Цаг хугацаа” (n=15) хэмээх үнэт зүйлийг олон сонгосон нь санамсаргүй зүйл биш бөгөөд Нико Дрокийн тодорхойлсон сэтгүүл зүйн мэргэжлийн 4 үнэт зүйлийн нэг (Drok, 2019, p.119) юм. Гэхдээ “Эх түүх, нүүдэлчин соёл, мал аж ахуй” гэсэн нэгэн үнэт зүйл хамгийн бага (n=5) сонгогдсон байгаа нь сэтгүүлчийн ангийн суралцагчдын хувьд орхигдон, бүдгэрч буй үнэт зүйл болохыг анхаарах шаардлагатай байна. Сүүлийн үед хэвлэл мэдээллийн салбарт үндэсний тодотголтой контент чухлаар тавигддаг болсон. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Олон нийтийн радио телевизийн тухай хуульд энэ төрлийн контент бүтээх зохицуулалт тусгасан байдаг. Тэгэхээр ийм контент туурвих эрмэлзэл төрүүлэхийн тулд энэхүү үнэт зүйлийг сургалтын явцад мэргэжлийн хандлага шингээн төлөвшүүлэх шаардлагатай болж байна.

**Амины үнэт зүйл:** Амины түвшний үнэт зүйлийн сонголтоор нийтлэг үнэт зүйл нь харин эрс ялгарч буй үр дүн (Зураг 1) гарсан байна. Амины түвшний үнэт зүйлсээс суралцагчид “Эрүүл мэнд” гэсэн үнэт зүйлийг хамгийн олон давтамжтай (n = 44) сонгожээ. Үүний дараагаар “Эрх чөлөө” (n = 27) болон “Оюун ухаан, мэдлэг боловсрол” (n = 25) гэсэн үнэт зүйлүүд илүү сонгогдсон байлаа.

Сэтгүүлч мэргэжил эрсдэл, ачаалал ихтэй мэргэжилд тооцогддог. Уэбстерийн “Мэдээлэл харилцааны толь”-д “Сэтгүүл зүй бол мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нийтлэх, нэвтрүүлэх үйл ажиллагаа юм” гэсэн тайлбар бий. “Сэтгүүлч бол нийгмийн салбаруудад, эсвэл нийгэмд бүхэлд нь мэдээлэл өгөхийн

тулд үйл явдлыг ажиглаж, тодорхойлон тайлбарладаг, баримтжуулдаг, мөн нийгэмд нөлөө үзүүлж буй үйл явдал, мэдэгдэл, бодлого, төлөвлөгөөнд шинжилгээ хийж, ийм мэдээллийг системд оруулах, баримт сэлт цуглуулах зорилготой хувь хүн юм” хэмээн НҮБ-ын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний Тусгай элчийн 2012 оны тайланд дурдсан байдаг (Наранжаргал, 2021, х. 154-155). Ачааллын хувьд “цагийн дарамтад ажиллаж /мэдээллийн амьд байх, ач холбогдолтой байх мөчлөг маш бага, мэдээлэгдээд л бол хэрэгцээгүй болж хувирдаг эрсдэлтэй/, оюуны үйл илүүтэй оролцдог боловч уран бүтээлийн шинж, үйлдвэрлэлийн шинж, бизнес /мэдээллийн/-ийн шинж хосолмол, аль аль талыг нь зохистой зохион байгуулахыг шаарддаг онцлогтой ажил мэргэжил юм. Маш өндөр хариуцлагатай тул ачаалал их. Ажлын үр дүн нийгмийн өмнө ил тод байдаг. Цагдан хяналт, мэдээллийн хомсдол, төрөл бүрийн шүүлтүүр, хэрэглэгчдийн хариу реакц, хуулийн болон ёс зүйн өндөр хариуцлага хүлээх зэргээр эрсдэл дунд ажилладаг мэргэжил. Энэ бүхнийг даван туулахад сэтгүүлч – бие хүний хувьд эрүүл мэнд маш чухал. Тиймээс амины үнэт зүйлийн жагсаалтыг эрхгүй тэргүүлжээ. Үүнийг ч сургалтаар сайтар тайлбарлаж, төлөвшүүлдэг.

“Эрх чөлөө” хэмээх үнэт зүйл бол иргэний мэдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэсэн сэтгүүл зүйн мэргэжлийн үнэт зүйлстэй нарийн нягт холбоотой. “Чухамхүү эдгээр чухал үнэт зүйлсийг ухамсарлах, эрхэмлэх нь сэтгүүлчийг төлөвшүүлдэг бөгөөд энэхүү ажил мэргэжлийн үнэ цэнийг өргөж байдаг юм (Ureneck, 2007, р.82). Суралцагчдын ийм амин чухал болоод нийтлэг үнэт зүйлийг мэргэжлийн үнэт зүйлстэй холбож, гүнзгийрүүлж мэргэжлийн хандлагыг төлөвшүүлэх нь сэтгүүл зүйн сургалтын үндсэн зорилго мөн.

“Оюун ухаан, мэдлэг боловсрол” -ын үнэт зүйл сэтгүүл зүйн боловсролд гурван түвшинд тайлбарлагддаг. Сэтгүүлч хүн нийгмийн өргөн хүрээний мэдлэгтэй байх шаардлагатай. Учир нь “Чөлөөт хэвлэл нь нийгмийн өмнө ямагт бодитой, олон ургалч байх, хувь хүмүүс өөр өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжит талбар байж, тэдэнд үйлчлэх үүрэг хүлээнэ” (Батбаатар, 2023, х.21). Онолын түвшинд сэтгүүлч нь танин мэдэхүйн өргөн хүрээний буюу ерөнхий мэдлэг, мэргэжлийн онол-практикийн мэдлэг, мэргэшсэн тусгай төрөлжсөн мэдлэгтэй байхыг (Зулькафиль, 2004, х.373) шаарддаг.

“Эв ээ”, “Хөгжил”, “Ажил хөдөлмөр”, “Эрдэм чанар”, “Амьдрах эв дүй” гэсэн үнэт зүйлсийг суралцагчид цөөн давтамжтай ( $n = 4$  болон  $n = 7$  хооронд) сонгосон нь анхаарах асуудал гэж үзэж байна.

“Эв ээ”, “Хөгжил”, “Амьдрах эв дүй” гэсэн үнэт зүйлсийг ерөнхий суурь хичээлүүдээр суралцагчдад сайтар төлөвшүүлж, нийгмийн үнэлэмжийг нь тогтооход сургалтын агуулга чиглэхүйц байвал зохистой.

“Ажил хөдөлмөр” гэдэгт бол сэтгүүлчийн мэргэжлийн хөдөлмөрийн үнэ цэнийг суралцагчдад бид ойлгуулж, ухамсарлуулж, мэдрүүлж хараахан чадаагүй байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. “Орчин үеийн нийгэмд иргэдийн мэдээллийн эрхэд үйлчлэх чухал үүрэг хүлээж, тэр хэрээрээ мэргэжлийн өндөр ёс зүй, хариуцлага шаардаж байдаг сэтгүүл зүйн хөдөлмөр нь олон үе шат дамжин хэрэгжих ихээхэн чимхлүүр, нарийн төвөгтэй үйл явц билээ” (Батбаатар, 2023,

х.123). Сургалтын хөтөлбөрийн “Сэтгүүлч мэргэжилтний хандлага”-д байгаа боловч энэхүү үнэт зүйлийг эрхэмлэх үзэл санаа бүрэлдээгүйн цаад шалтгааныг судлан шинжилж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд тусгайлан тусгах шаардлагатай нь харагдаж байна.

**Ухамсрын үнэт зүйл:** Ухамсрын түвшний үнэт зүйлийн сонголтоор нийтлэг үнэт зүйл нь харьцангуй тархмал шинжтэй судалгааны үр дүн (Зураг 1) гарчээ. Ухамсрын түвшний “Ёс суртахуун” (n = 28) болон “Хүн ёс, хүн чанар” (n = 26) хэмээх үнэт зүйлс хамгийн олон сонголттой байна. Энэ нь мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахих болон ёс суртахуунлаг харилцааг эрхэмлэдэг байхтай холбоотой. Үүний дээр “Энэрэх, нигүүлсэх сэтгэл” (n = 15) гэсэн үнэт зүйлд олон сонголт байгаа нь сэтгүүлч болох оюутнуудын хувьд чухал итгэл үнэмшил, эрхэмлэл юм. Эдгээр үнэт зүйлс мэргэжлийн нэг чухал үндсэн зарчимтай шууд холбогдоно. Энэ нь “хүндлэг байх” зарчим бөгөөд “Хэн нэгнийг гүтгэж, эрээ цээргүй доромжилж хувь хүний нууц, эрх, эрх чөлөө, нэр хүндэд халдах нь тухайн хүний төдийгүй гэр бүл, үр хүүхэд, орчин тойрныхныг нь ч сэтгэл санааны дарамт, хүнд байдалд оруулж болох эрсдэлийг бодон сэтгүүлч хүнлэг энэрэнгүй чанарыг урьтал болгодог байвал зохино” (Батбаатар, 2023, х.54). “Хүнлэг хандлагын үндэс нь хүн бол нийгэм дэх бүх зүйлийн хэмжүүр гэсэн төсөөлөл бөгөөд энэ нь хүний мөн чанар, онцлогт тохирсон амьдралын нөхцөлийг бий болгохыг шаарддаг” (Зулькафиль, 2021, х.374) гэсэн утгуудаар тайлбарлагддаг. Ийм үзэл санааг сургалтаар суралцагчид маань ойлгож, ухамсарласны үр дүн юм.

“Хүндлэл” /нэр төр/ гэсэн үнэт зүйл 20 сонголттой гуравдугаарт эрэмбэлэгдэж байна. Үүнийг суралцагчдын мэргэжлийн итгэл үнэмшлийн утгаар авч үзэж болно. Мэргэжлийн нэр хүндийг эрхэм чанараа болгож, сайн сэтгүүлч болох хүсэл эрмэлзэл төрүүлж чадсан байна. Сэтгүүл зүйд “ёс зүйтэй сэтгүүлчид нь эх сурвалжууд, субъектүүд болон хамтран ажиллагсдаа хүндэтгэл хүлээх ёстой хүмүүс гэж ханддаг” байх ёстой (Батбаатар, 2023, х.39) хэмээн Америкийн мэргэжлийн сэтгүүлчдийн холбооны “Ёс зүйн дүрмийн 2 дугаар зарчимд заажээ. Энэ бол хувь хүний нэр төрийн хүрээний үнэт зүйл бус мэргэжлийн нэр төрийн хүрээнд холбогдох үнэт зүйл болж төлөвшиж, суралцагчдын ухамсрын түвшний үнэт зүйлст байр суурь эзэлж байгааг илтгэсэн хэрэг юм.

“Эх хэл” /хэрэглээ соёл/ хэмээх үнэт зүйл ухамсрын түвшний үнэт зүйлийн бүрдүүлбэрт цөөнгүй (n = 16) давтамжтай сонгогдсон нь мэргэжлийн онцлогтой, ялангуяа бичих, найруулах, эх хэлээрээ мэдээллийг боловсруулах чадвар чухлыг суралцагчид маань ухамсарлаж байгаагийн илэрхийлэл болж байна.

Харин “Хамтач үзэл, хамтын ажиллагаа” (n = 9), “Нөхөрсөг харилцаа (n = 6) гэсэн үнэт зүйлс цөөн сонгогдсонд анхаарч, сургалтын арга барил, багаар ажиллах, редакц хамт олны бүтээлч хамтын ажиллагааны талаарх ухамсар төлөвшүүлэх шаардлага тулгарч байна хэмээн үзэх үндэслэл болж байна. Мөн “Итгэл үнэмшил, сүсэг бишрэл” (n = 5) гэсэн үнэт зүйлийг сайтар бүрэлдүүлэхийн чухлыг ч анхаарах ёстой.

Ийнхүү сэтгүүл зүйн мэргэжлээр суралцагчдын хувь хүний үнэт зүйлсийн судалгааг “Нэгэн хүний амин хүрээний үнэт зүйлийн гурвалууд”-ын загварчилсан



асуулгаар авч, үр дүнд задлан шинжилгээ хийж үзэхэд суралцагчдын үнэт зүйлийн нийтлэг нь ахуйн, амины, ухамсрын түвшинд харилцан адилгүй байсан нь сонирхол татлаа.

Гол нь эдгээр үнэт зүйлсийн ямар нь эерэг үзүүлэлттэй (олон сонгогдсон) байгаад мэргэжлийн сургалтаар эзэмшүүлж буй чухал ойлголт, мэдлэг төлөвшүүлж буй хандлага нөлөөлснийг тайлбарлаж болохуйц байна. Харин чухал зарим үнэт зүйлсийг цөөн сонгосон нь мэргэжлийн сургалтын ямар мэдлэг, ойлголтын сул нөлөөллөөс шалтгаалж байгаатай холбон үзэж, сургалтын арга зүй, агуулгад анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Улмаар судалгаанд тулгуурлаж суралцагчдын мэргэжлийн хандлагыг бие хүний үнэт зүйлийг харгалзан төлөвшүүлэх нь оновчтой гэсэн үзэл баримтлал дэвшүүлж байна.

Үүнийг бататгахын тулд сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрөөр эзэмшүүлэх хандлагатай холбож шинжилгээ хийв. 2021 онд шинэчлэн боловсруулсан Сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөр дэх суралцагчдад төлөвшүүлэх “Сэтгүүлчийн мэргэжлийн хандлага”-ыг (Хүснэгт 3) үзүүлэв.

### Хүснэгт 3

Сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрөөр суралцагчдад төлөвшүүлэх хандлага

#### Сэтгүүлчийн мэргэжлийн хандлага

- 1.1. Хэвлэлийн эрх чөлөөг эрхэмлэн дээдэлсэн чөлөөт хэвлэлийн үзэл баримтлал төлөвшиж, мэргэжлийн үндсэн үүрэг зорилго, баримтлах зарчмаас гажихгүй, ямагт мөрдлөг болгодог байх,
- 1.2. Үнэнийг эрхэмлэж, мэдээллийг нягталж, хууль сахиж, ёс суртахууныг дээдлэн иргэд олон нийтийн мэдэх эрхэд үйлчлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлах чин эрмэлзэлтэй байх
- 1.3. Дэлхийн болон үндэсний сэтгүүл зүйн хөгжлийг бодитоор үнэлж, өнөөгийн хөгжлийн хандлагатай зэрэгцэн нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд хувь нэмэр оруулах итгэл үнэмшилтэй байх
- 1.4. Сэтгүүл зүйн онол, практикийн тулгуур ойлголтуудыг судлан шинжилж, салбарын орчин үеийн чиг хандлагыг мэдэрч, сэтгүүл зүйн шинэлэг урсгал чиглэлүүдээр нарийн мэргэшин, техник технологийн дэвшлийг чадварлаг ашиглаж, мэргэжлийн төвшинд өөрийгөө ямагт хөгжүүлж байх
- 1.5. Мэдээ мэдээллийг сонгож, боловсруулан хүргэхдээ хувийн үзэл бодол, хандлагаар хандах бус нийгэм, олон нийтийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж, шүүмжлэлт сэтгэлгээ, ардчиллын түгээмэл зарчмыг тулгуур болгох
- 1.6. Сэтгүүл зүйн бүтээл туурвих онолын мэдлэг, чадварыг төгс эзэмшин, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өвөрмөц онцлогт тохируулан хэрэглэж, мэргэжлийн талбарт олон талт байдлаар хөрвөн ажиллах чиг баримжаатай болох
- 1.7. Сэтгүүлч хүн өөрийн мэдлэг боловсрол, авьяас, чадвараараа мэргэжил нэгтгүүдтэйгээ төдийгүй нийгэмд шударгаар өрсөлдөж, өөрийн байр сууриа

олж, хүлээн зөвшөөрөгдөж, мэргэжлийн өндөр түвшинд хүрсэн, сайн сэтгүүлч болдог гэдгийг ухамсарлан, үүнд өөрийгөө дайчлах

Эдгээр хандлагыг бие хүний үнэт зүйлстэй ямар тохирцтой байгааг (хүснэгт 4) харгалзуулж, үнэлгээ хийв.

#### Хүснэгт 4

“Нэгэн хүний амин хүрээний үнэт зүйлийн гурвалууд” ба суралцагчдад төлөвшүүлэх мэргэжлийн хандлага

АХУЙН ТҮВШИН	Холбогдох хандлага	АМИНЫ ТҮВШИН	Холбогдох хандлага	УХАМСРЫН ТҮВШИН	Холбогдох хандлага	
1	Байгаль дэлхийн хамгаалал	1.2.	Эрүүл мэнд	Хүндлэл (нэр төр)	1.2., 1.7.	
2	Эх орон, газар шороо	1.2.,	Ажил хөдөлмөр	1.1., 1.5., 1.4., 1.6., 1.7.,	Итгэл үнэмшил, сүсэг бишрэл	1.2., 1.3.,
3	Хүмүүнлэг иргэний нийгэм	1.1., 1.2., 1.3., 1.5.	Амьдрах ухаан, эв дүй	1.4., 1.7.	Энэрэх, нигүүлсэх сэтгэл	1.1., 1.2., 1.5., 1.7.
4	Эдийн засаг (эд хөрөнгө, баялаг)	1.6., 1.5.	Эрдэм чанар (авьяас чадвар)	1.1., 1.2., 1.4., 1.6., 1.7.	Ёс суртахуун	1.1., 1.2., 1.5.
5	Эх түүх, нүүдэлчин соёл, мал аж ахуй	1.3.	Гэр бүлийн аюулгүй байдал		Хүн ёс, хүн чанар	1.1., 1.2.
6	Тусгаар тогтнол	1.1., 1.2., 1.3., 1.5., 1.7.	Оюун ухаан, мэдлэг боловсрол	1.4., 1.5., 1.6.,	Хамтач үзэл (хамтын ажиллагаа)	1.4., 1.6., 1.7.
7	Ёс заншил, өв соёл, уламжлал	1.3.	Хөгжил (Тогтвортой хөгжил)	1.3.	Эх хэл (хэрэглээ соёл)	1.3.
8	Цаг хугацаа	1.1., 1.5.	Эв эе (найрамдал, энх тайван)	1.2.	Нийгмийн байр суурь (нэр хүнд, алдар гавьяа)	1.7.
9	Хүний эрх, тэгш байдал	3.1., 3.2., 3.4., 3.5.	Эрх чөлөө	1.1., 1.2., 1.5., 1.6.	Нөхөрсөг харилцаа	1.2., 1.7.

Эндээс харвал сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрөөр суралцагчдадаа төлөвшүүлэх хандлага хамгийн өндөр тохирцтой үнэт зүйлсэд, Ахуйн түвшинд “Хүмүүнлэг иргэний нийгэм”, “Тусгаар тогтнол” болон “Хүний эрх, тэгш байдал” гэсэн 3 үнэт зүйл байгаа нь оюутнуудын хувь хүний үнэт зүйлийн нийтлэг буюу олон давтамжтай сонгосон сонголттой нийцэж байлаа.

Амины түвшинд “Ажил хөдөлмөр”, “Эрдэм чанар (авьяас чадвар)”, “Эрх чөлөө” болон “Оюун ухаан, мэдлэг боловсрол” гэсэн 4 үнэт зүйл тохирц ихтэй байгаа ч хамгийн олон сонголт авсан “Эрүүл мэнд” гэсэн үнэт зүйл сургалтын хөтөлбөр дэх хандлагуудад тусаагүй нь анхаарал татсан.

Ухамсрын түвшинд “Энэрэх, нигүүлсэх сэтгэл”, “Ёс суртахуун” болон “Хамтач үзэл” (хамтын ажиллагаа, багаар ажиллах) гэсэн үнэт зүйл төлөвшүүлэх хандлагатай тохирцтой байв. 1-2 хандлага хамаарах үнэт зүйл 15 байгаа нь сургалтын хөтөлбөрт үнэт зүйлд суурилсан хандлага төлөвшүүлэх үзэл баримтлалыг шинэчлэн тусгах шаардлагатайг илтгэж байна. Ялангуяа, “Хүндлэл”, “Эх хэл” гэсэн үнэт зүйлсийг хөтөлбөрийн хандлагад ямар нэг байдлаар томьёолж тусгаагүйг анхаарах хэрэгтэй байна.

Ер нь сургалтын хөтөлбөрөөр суралцагчдад төлөвшүүлэх хандлагыг ч суралцагчдын хувь хүний үнэт зүйлийн нийтлэгийг харгалзаж, нийгмийн үнэт зүйлстэй холбон шинэчлэн боловсруулах, үүнээс шалтгаалан хөтөлбөрийн шинэчлэл хийх шаардлагатай гэсэн асуудлыг дэвшүүлж байна.

Учир нь “Бид тодорхой ур чадвар, ялангуяа техникийн ур чадварт анхаарлаа хандуулахын оронд оюутнуудад үнэ цэн, хандлагыг төлөвшүүлэхээр ажиллаж байна” (Ureneck, 2007, х.83) гэсэн дэвшилтэт санааг сургалтын хөтөлбөртөө бүрэн дүүрэн тусгаж, шинэчлэл хийх шаардлагатай болжээ.

## Дүгнэлт

Сэтгүүл зүйн мэргэжлээр суралцагчдын хувь хүний үнэт зүйлсийг судлан, үр дүнг мэргэжлийн онолын ойлголт, үзэл баримтлал, суралцагчдад хөтөлбөрөөр төлөвшүүлж буй хандлагатай уялдуулж шинжилсэн судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг хийж байна.

1. Суралцагчдын нэгэн хүмүүний амины хүрээний үнэт зүйлсийн гурвалууд нь дараах шинжтэй байв.
  - a. Гурвалуудаас ахуйн түвшний үнэт зүйлийн сонголт ихээхэн тархмал байна. Гэхдээ “Хүний эрх, тэгш байдал”, “Тусгаар тогтнол” “Хүмүүнлэг иргэний нийгэм” гэх үнэт зүйлсийг хамгийн олон давтамжтай сонгосон нь сэтгүүлч хүнд байх чухал үнэт зүйлс бөгөөд сургалтын хүрээнд сэтгүүл зүйн боловсрол, мэргэжилтэнд төлөвшүүлэх хандлагуудтай холбоотойгоор суралцагчдад төлөвшиж байна.
  - b. Харин амины түвшний үнэт зүйл нь “Эрүүл мэнд”, “Эрх чөлөө”, “Оюун ухаан, мэдлэг боловсрол” эрс ялгарч сонгогдсон буюу үүгээрээ суралцагчдын үнэт зүйлийн нийтлэг тогтолцоог бүрдүүлсэн байна. Гэхдээ “Эрүүл мэнд” хэмээх хамгийн их сонгогдсон үнэт зүйл сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрийн хандлагад тодорхой бус байгааг анхаарах шаардлагатай.
  - c. Ухамсрын түвшний үнэт зүйлийн сонголт нь харьцангуй тархмал шинжтэй үр дүн гарчээ. “Ёс суртахуун”, “Хүн ёс, хүн чанар”, “Хүндлэл” /нэр төр/, “Энэрэх, нигүүлсэх сэтгэл” зэрэг үнэт зүйл

нь сургалтын хөтөлбөрийн суралцагчдад төлөвшүүлэх олон хандлагад давтагдаж туссан нь нөлөөлсөн байх магадлалтай.

2. Суралцагчдын хувь хүний үнэт зүйлс нь ийнхүү мэргэжлийн онцлог, сэтгүүл зүйн үүрэг зорилго, зарчимтай холбогдож байгаа нь сэтгүүл зүйн сурах бичиг, холбогдох баримт бичгүүдийн үзэл баримтлалаар батлагдаж байна. Гэхдээ зарим чухал үнэт зүйлс сургалтын хөтөлбөр дэх мэргэжилтний хандлагад орхигдоод буйг анхаарах, улмаар сургалтын агуулга, арга зүйд тусгах нь чухлыг илтгэж байв.
3. Сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрөөр суралцагчдад төлөвшүүлэх хандлага нь хувь хүний үнэт зүйлийн гурвалуудын тал хүрэхгүй хувьтай нь тохирцтой байгаа ч суралцагчдын хамгийн олон давтамжтай сонгосон сонголтын дийлэнх үнэт зүйлстэй холбоотой байна. Энэ нь сэтгүүл зүйгээр суралцагчдад хувь хүний үнэт зүйлс бүрэлдэхэд нь мэргэжлийн сургалтаар төлөвшүүлж байгаа хандлага нөлөөлснийг илтгэж буй хэрэг юм.

Эцэст нь суралцагчдын хувь хүний үнэт зүйлсийг судалж, тэдэнд төлөвшүүлэх мэргэжлийн хандлагыг суралцагчдын үнэт зүйлсийн бүрдүүлбэртэй уялдуулах хөтөлбөрийн шинэчлэл хийх нь сэтгүүл зүйн сургалтын шинэлэг үзэл баримтлал болно.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

- Committee, D. (1948). *General Assembly resolution 217 A. Universal Declaration of Human Rights, Article 19*. Palais de Chaillot, Paris. <https://documents-dds-ny.un.org/doc/RESOLUTION/GEN/NR0/043/88/PDF/NR004388.pdf?OpenElement>
- Drok, N. (2019). *Journalistic Roles, Values and Qualifications in the 21st century : how European journalism educators view the future of a profession in transition*. Netherlands: Hogeschool Windesheim
- Fischer, C. A. (2019). *Werte als Kerne von Kompetenzen. Eine theoretische Studie mit einer empirischen Analyse in Montessori-Schulen*. Münster: Waxmann. Ludwig-Maximilians-Universität München.
- John Erpenbeck, W.S. (2018). *Wertungen, Werte-Das Fieldbook fuer ein erfolgreiches Wertemanagement*. Berlin, Heidelberg: Springer. doi: <https://doi.org/10.1007/978-3-662-54779-3>
- Paul H. P. Hanel, Colin Foad and Gregory R. Maio. (2021). *Attitudes and Values. Psychology*. United Kingdom: Oxford University Press. doi: <https://doi.org/10.1093/acrefore/9780190236557.013.248>
- Schwartz, S. (2010). Are there Universal Aspects in the Structure and not Content of Human Values? In M. Ros, & V. Gouveia (Eds.). *Journal of Social Issues*, pp. 19-45. doi: <https://doi.org/10.1111/j.1540-4560.1994.tb01196.x>
- Ureneck, L., (Ludtke, M, Хян). (2007). Values Reside at the Core of Journalism. *Nieman reports*, 61 (3), 82.
- Батбаатар, Ж. (2023). *Суурь сэтгүүл зүй*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

- Батзориг, Т. (2019). *Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Зулькафиль, М. (2004). *Сэтгүүл зүйн онолын үндэс*. Улаанбаатар: Китаб.
- Болд-Эрдэнэ, Б., Зулькафиль, М нар. (2021). *Сэтгүүл зүйн үндэс*. Улаанбаатар: МУИС хэвлэлийн газар.
- Наранжаргал, Х. (2021). *Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй*. Улаанбаатар: Чөлөөт хэвлэл сан.
- Санчес, А. К. (2000). *Үнэт зүйлсийн төлөвшил: онол, эргэцүүлэл ба хариулт*. Мексик: Григалбогийн редакц.
- Сүхболд, Б. (2021). *Үнэт зүйлийг нэг ертөнцийн хандлагын үүднээс шинжихүй*. Улаанбаатар: МУБИС хэвлэх цех.

## Exploring the Relationship Between Personal Values and Professional Attitude of Journalism Students

Amartuvshin Sukhee

*Department of Journalism, School of Social Sciences and Humanities, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

Corresponding author: [amartuvshin@msue.edu.mn](mailto:amartuvshin@msue.edu.mn)

ORCID: <https://orcid.org/0000-0001-8940-3268>

---

Received: 2023.02.22

Revised: 2023.05.12

Accepted: 2023.05.22

---

### Abstract

Numerous studies have investigated the correlation between personal values and the quality of education among journalism students. However, limited research has been conducted on the connection between personal values and the professional attitudes of journalists. To address this research gap, we conducted a survey among 45 students (representing 53.09% of all students) enrolled in the Journalism Program at MNUE (Mongolian National University of Education). The objective was to identify their unique values and define shared principles. The survey employed questionnaires that required participants to select three values from each of the following categories: livelihood, health, and intellect. These questionnaires were then processed using the SPSS-26 program, following the "Triads of Values of a Person" model established by previous researchers. The novelty and focus of this article are emphasized by the examination of the collected data in relation to professional education and students' attitudes towards training. The results revealed significant diversity in the

---

selection of values within the Livelihood category, while values associated with health exhibited the highest frequency (n = 44 for "Health," n = 27 for "Freedom," and n = 25 for "Intellect and knowledge"), indicating a consistent system of values. The Intellect category demonstrated relatively common value selection. Considering the potential connection between these outcomes and the "attitude of a specialist journalist" within the journalism curriculum, an analysis was conducted. Based on the analysis, this article advances the notion that assisting students in establishing a professional attitude based on their personal values is more crucial than solely focusing on knowledge acquisition and skill development during their professional training.

**Keywords:** Personal values, professional characteristics, basic principles of journalism, professional attitude